

БАТЛАВ,  
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ХҮРЭЛБААТАР

## АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 1. Аудитын нэр:

2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц

### 2. Аудитын код:

САГ-2018/02-СА

### 3. Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний 38 дахь заалтыг үндэслэн гүйцэтгэнэ.

### 4. Аудитын зорилт:

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сан болон Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулиудын хэрэгжилтийн явцыг шалгаж, дүгнэлт гарган Улсын Их Хуралд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- 2018 оны төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөсөн эсэх,
- 2018 оны төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх,
- 2018 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулж буй эсэх,
- ТЕЗ-дын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшинд нийцсэн эсэх.

### 5. Аудитын хамрах хүрээ:

Аудитыг Засгийн газрын байгууллагуудын ТЕЗ-дын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд болон Орон нутгийн ТЕЗ-дын 2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад холбогдох баримт материалд тулгуурлан гүйцэтгэнэ.

### 6. Үндсэн мэдээлэл:

Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны



төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулийг тус тус баталсан байна.

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар:

- Монгол Улсын төсөвт 2018 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 5,207,337.2 сая төгрөг,
- Монгол Улсын төсвөөс 2018 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын /тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн/ хэмжээг 7,710,777.6 сая төгрөг,
- Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн дүнг 683,319.8 сая төгрөг,
- "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн эргэн төлөлтийн дүнг 82,884.4 сая төгрөг,
- 2018 оны төсвийн жилд хуримтлуулах хөрөнгийн хэмжээг Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Ирээдүйн өв санд 508,744.3 сая, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн тогтворжуулалтын санд 122,747.2 сая төгрөг,
- Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу 2018 оны төсвийн жилд Ирээдүйн өв сангийн эх үүсвэрээс улсын төсөвт олгох шилжүүлгийн хэмжээг 100,000.0 сая, уг хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу 2018 оны төсвийн жилд сангийн эх үүсвэрээс улсын төсөвт төлөх өглөг барагдуулалтын хэмжээг 408,744.3 сая төгрөг,
- 2018 оны төсвийн жилд улсын төсвөөс нэр бүхий 15 аймгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг нийт 180,700.9 сая төгрөг,
- Нийслэл болон нэр бүхий 4 аймгийн орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын нийт хэмжээг 289,228.4 сая төгрөг,
- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих урсгал зарлагын хэмжээг 88,555.0 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Засгийн газрын 2018 оны төсвийн жилд нэмэгдүүлэх өр болон өрийн баталгааны дээд хэмжээг 2,583,181.9 сая төгрөгөөр тогтоожээ.

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2018 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт", 2, 3 дугаар хавсралтаар улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын болон концессын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт, 4 дүгээр хавсралтаар "Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс 2018 онд сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох урамшуулал, дэмжлэг"-ийг тус тус баталсан байна.

Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулиар сангийн нийт орлогыг 1,911,227.4 сая, нийт зарлагыг 1,808,255.2 сая, Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат бонд худалдан авахад зарцуулах хөрөнгийн дээд хэмжээг 300,000.0 сая төгрөгөөр тус тус баталжээ.



Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулиар сангийн нийт орлогыг 376,011.9 сая, нийт зарлагыг 341,330.5 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

#### **7. Аудитын арга зүй:**

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын Дээд байгууллагуудын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын болон Гүйцэтгэлийн аудитын журам, арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулна. (Аудитын асуудлын шинжилгээ, арга зүйг хавсралт №1, 2-оос үзнэ үү)

#### **8. Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:**

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын багц хуулиуд
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Өрийн удирдлагын тухай хууль
- Ирээдүйн өв сангийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль
- Бусад холбогдох хууль, тогтоомж, журам, зааврууд

#### **9. Аудит хийх хугацаа:**

Аудитыг 2018 оны 9 дүгээр сарын 03-наас эхэлж, аудитын тайлангийн төслийг 12 дугаар сарын 03-нд дуусгаж, Үндэсний аудитын газрын аудитын болон удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторроор баталгаажуулсан аудитын тайланг 2018 оны 12 дугаар сарын 14-нд Улсын Их Хуралд хүргүүлнэ. (Аудитын хөтөлбөр, хуваарийг хавсралт № 3-аас үзнэ үү)

#### **10. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:**

Аудитыг Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг удирдан, аудитын менежер С.Оюунгэрэл анхан шатны чанарын



хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ш.Ичинхорлоо, Д.Цэрэндорж болон Хоёрдугаар албаны бусад аудиторрууд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг аймаг, нийслэлийн Төрийн аудитын газрууд гүйцэтгэж тайлагнах бөгөөд тэдний ирүүлсэн аудитын тайлан, судалгааг нэгтгэж нэгдсэн тайланд тусгана.

## 11. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл:

Аудитын тайлан нь Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн болон Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явцад хийсэн аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмжтэй байхаас гадна хавсралт гэсэн агуулгатай байна. Үүнд:

Монгол Улсын 2018 оны төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөсөн эсэх хэсэгт: Монгол Улсын нэгдсэн төсвийн болон Улс, орон нутгийн төсөв, Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн үндэслэл,

2018 оны төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх хэсэгт: төсвийн жилд Монгол Улсын нэгдсэн болон Улс, орон нутгийн төсөв, Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын төсвийн орлогын гүйцэтгэл, тогтворжуулалтын болон ирээдүйн өв санд хуримтлуулах хөрөнгийг бүрэн төвлөрүүлсэн эсэх, төсөвт болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудад орлого нэмэгдүүлэх боломжийг судалж тусгах,

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулсан эсэх хэсэгт: Монгол Улсын нэгдсэн болон Улс, орон нутгийн төсөв, Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын төсвийн зарлагын гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн шалтгаанд дүн шинжилгээ хийх;

Засгийн газрын байгууллагуудын Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилтот түвшинд нийцсэн эсэх хэсэгт: Засгийн газрын байгууллагуудын Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн төлөвлөсөн хөтөлбөр арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийн зохистой байдал, түүний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх.

## 12. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц:

А. Боловсон хүчин:

- Үндэсний аудитын газар - 9 хүн
- Нийслэл дэх төрийн аудитын байгууллага – 19
- Аймаг дахь төрийн аудитын байгууллага – 73, **нийт - 106**

Б. Санхүүгийн нөөц:

- Цалин, нийгмийн даатгалын шимтгэл /106 ахлах аудитор, аудитор/ - 498.9 сая төгрөг
- Дотоод албан томилолт /92 ахлах аудитор, аудитор/ - 61.7 сая төгрөг
- Бичиг хэргийн зардал – 0.2 сая төгрөг



В. Техник хэрэгсэл:

- Зөөврийн компьютер, видео камер, зургийн аппарат
- Бусад техник хэрэгсэл

Аудитын төлөвлөгөөг

Хянаж зөвшөөрсөн:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ

Боловсруулсан:

ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Three handwritten signatures in blue ink, corresponding to the roles listed on the left.

Ц.НАРАНЧИМЭГ

С.ОЮУНГЭРЭЛ

Ш.ИЧИНХОРЛОО